



ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/17

Зуунмод

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан “Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагнал журам”, Аймгийн Засаг даргын 2017 оны А/160 тоот захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Аймгийн Засаг даргаас олгох шагналын журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Ногоон модон луужил” жилийн хаврын тэргүүн сар шинийн баярыг тохиолдуулан Улсын хошой аварга малчин-1, Улсын аварга малчин-10, Улсын аварга фермер-2, Улсын аварга саальчин-1, Улсын аварга тариаланч хамт олон-3, Улсын аварга тариаланч-2 тус тус төрөн гарсан тул хүндэтгэл үзүүлэхэд гарах зардлыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2.Аймгийн хошой аварга малчин-10, аймгийн аварга малчин-100, аймгийн аварга фермер-5, аймгийн аварга саальчин-5, аймгийн аварга хадланч-5, Ж.Самбуугийн нэрэмжит аймгийн залуу аварга малчин-30, Алтан төлийн эзэн-10, аймгийн аварга тариаланч хамт олон-5, аймгийн аварга тариаланч-9, Ц.Цэрэн-Очирын нэрэмжит аймгийн залуу аварга тариаланч-15 тус тус төрөн гарсан тул хүндэтгэл үзүүлэхэд гарах зардлыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3.Шагналд зарцуулагдах 85,815,100 (наян таван сая найман зуун арван таван мянга нэг зуу) төгрөгийг нэмэлт санхүүжүүлэлтийн данснаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т, зарцуулахыг Засаг даргын Тамгын газар (М.Отгонбат)-т тус тус зөвшөөрсүгэй.

4.Арга хэмжээний бэлтгэлийг бүрэн хангуулж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Н.Гантулга)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА




Д.МӨНХБААТАР

Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр
сарын 12 -ны өдрийн А/17 дүгээр
захирамжийн 7 дүгээр хавсралт



УЛСЫН АВАРГУУДАД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭХ
ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Улсын хошой аварга малчинд олгох дурсгалын зүйл	1	350,000	350,000
2	Улсын аварга малчинд олгох дурсгалын зүйл	10	350,000	3,500,000
3	Улсын аварга фермеролгох дурсгалын зүйл	2	350,000	700,000
4	Улсын аварга саальчинд олгох дурсгалын зүйл	1	350,000	350,000
5	Улсын аварга тариаланч хамт олонд олгох дурсгалын зүйл	3	350,000	1,050,000
6	Улсын аварга тариаланчид олгох дурсгалын зүйл	2	350,000	700,000
НИЙТ ДҮН				6,650,000

ТӨСӨВ ХИЙСЭН:
ГАЗАР ТАРИАДАНГИЙН АЛБАНЫ
ДАРГА  С.ГАНЧИМЭГ
МАЛ ҮРЖЛИЙН АЛБАНЫ
ДАРГА  М.ТУЯА

ТӨСӨВ ХЯНАСАН:
СТСХ-ИЙН ТӨСВИЙН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН  Ж.ЭРДЭНЭЖАРГАЛ

Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр
сарын 12 -ны өдрийн А/7 дүгээр
захирамжийн 2 дугаар хавсралт

АЙМГИЙН АВАРГУУДАД ОЛГОХ ШАГНАЛЫН
ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Аймгийн хошой аварга малчинд олгох дурсгалын зүйл /цом/	10	350.000	3.500.000
2	Аймгийн аварга малчинд олгох дурсгалын зүйл /цом/	100	350.000	35.000.000
3	Ж.Самбуугийн нэрэмжит аймгийнзалуу аварга малчинд олгох дурсгалын зүйл	30	300.000	9.000.000
4	Аймгийн аварга фермер, тариаланч хамт олонд олгохтүг	5+5	80.000	800.000
5	Аймгийн аварга саальчин, фермерт олгох дурсгалын зүйл /агар хувин/	5+5	250.000	2.500.000
6	Аймгийн алтан төлийн эзэнд олгох дурсгалын зүйл /цом/	10	250.000	2.500.000
7	Аймгийн аварга тариаланч хамт олон, аварга тариаланчид олгох дурсгалын зүйл /тариан түрүүтэй метал, цом /	5+10	350.000	5.250.000
8	Аймгийн хадланчид олгох дурсгалын зүйл	5	300.000	1.500.000
9	Ц.Цэрэн-Очирын нэрэмжит аймгийн залуу аварга тариаланчид олгох дурсгалын зүйл	15	300.000	4.500.000
10	Аваргын тууз	186	25.000	4.650.000
11	Аваргуудын хавтастай батламж	194	25.000	4.850.000
12	Аймгийн хошой аварга, аварга малчины энгэрийн тэмдэг	110	20.350	2.238.500
13	Ж.Самбуугийн нэрэмжит аймгийн Залуу аварга малчины энгэрийн тэмдэг	30	26.400	792.000
14	Алтан төлийн эзэний энгэрийн тэмдэг	10	26.400	264.000
15	Аймгийн аварга тариаланч, аварга хадланчийн энгэрийн тэмдэг	9+5	26.400	369.600
16	Ц.Цэрэн-Очирын нэрэмжит аймгийн Залуу аварга тариаланчийн энгэрийн тэмдэг	15	26.400	396.000
17	Хадаг	211	5.000	1.055.000
НИЙТ ДҮН				79,165,100

ТӨСӨВ ХИЙСЭН:

ГАЗАР ТАРИАЛАНГИЙН АЛБАНЫ ДАРГА
МАЛ ҮРЖЛИЙН АЛБАНЫ ДАРГА

С.ГАНЧИМЭГ
М.ТУЯА

ТӨСӨВ ХЯНАСАН:

СТСХ-ИЙН ТӨСВИЙН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН

Ж.ЭРДЭНЭЖАРГАЛ